



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/19-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn
2025 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9
5. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	9

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.25 № 158
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 374,145.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй;
2. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 57,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6

дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,460,961.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,166,325.0 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 294,636.3 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 72.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	781,627.4	934,661.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	203,336.0	396,116.7
33	АВЛАГА	497,808.4	383,985.4
35	БАРАА МАТЕРИАЛ	63,108.0	72,695.1
36	НӨӨЦИЙН БАРАА	17,375.0	81,864.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,045,570.8	2,024,237.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,045,570.8	2,024,237.7
39200	Биет хөрөнгө	2,024,517.3	2,003,306.7
39300	Биет бус хөрөнгө	21,053.5	20,931.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,827,198.2	2,958,899.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,827,198.2	2,958,899.0
51	Засгийн газрын хувь оролцоо	2,827,198.2	2,958,899.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	496,878.3	496,878.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,031,620.2	2,163,321.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,699.6	298,699.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,827,198.2	2,958,899.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,473,531.3	2,776,661.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	620,999.2	1,035,713.5
110	Орлогын албан татвар	359,602.4	926,288.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	359,453.9	926,173.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	148.5	115.5
113	Хөрөнгийн албан татвар	155,561.0	61,037.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,835.8	48,388.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	345,057.8	484,186.8
120	Нийтлэг татварын бус орлого	345,057.8	484,186.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,507,474.3	1,256,761.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,931,807.6	2,270,944.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,931,807.6	2,270,944.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,585,909.3	2,140,484.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,785.1	754,254.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,253.0	93,066.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,706.8	254,251.2
2104	Хангамж, бараа материалын зардал	88,311.8	146,224.7
2105	Нормативт зардал	1,720.0	2,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,817.0	176,758.3
2107	Томилолт, зочны зардал	9,813.1	10,222.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	304,441.5	71,810.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	555,061.0	631,896.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,345,898.3	130,460.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	541,723.7	505,716.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	577,057.1	374,016.1

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-35,333.4	131,700.8
-----------	--	-----------	-----------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,298,348.4	2,444,020.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	620,999.2	1,035,713.5
110	Орлогын албан татвар	359,602.4	926,288.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	359,453.9	926,173.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	148.5	115.5
113	Хөрөнгийн албан татвар	155,561.0	61,037.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,835.8	48,388.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	47,990.3	28,080.6
1181	Газрын төлбөр	35,500.0	1,609.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	22,345.6	18,697.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,874.8	146,075.6
120	Нийтлэг татварын бус орлого	169,874.8	146,075.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,507,474.3	1,262,231.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,507,682.5	1,788,569.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,507,682.5	1,788,569.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,162,034.2	1,654,805.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,019.4	752,915.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,577.6	93,737.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,235.8	253,961.2
2104	Хангамж, бараа материалын зардал	65,393.3	93,741.6
2105	Нормативт зардал	1,500.0	2,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,540.0	180,295.3
2107	Томилолт, зочны зардал	8,499.0	10,222.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,381.5	133,547.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,887.6	134,384.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,345,648.3	133,764.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	790,665.9	655,450.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	655,242.9	447,569.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	655,242.9	447,569.9
2200	Дотоод эх үүсвэрээр	655,242.9	447,569.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-655,242.9	-447,569.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-149,845.0	-15,100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	149,845.0	15,100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-14,422.0	192,780.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	217,758.1	203,336.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	203,336.0	396,116.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,867,326.0	2,867,326.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,794.4	-4,794.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,862,531.6	2,862,531.6
4	Тайлант үеийн үр дүн	-35,333.4	-35,333.4
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,827,198.2	2,827,198.2
6	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,827,198.2	2,827,198.2
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,827,198.2	2,827,198.2
8	Тайлант үеийн үр дүн	131,700.8	131,700.8
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,958,899.0	2,958,899.0

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,460,961.30	2,166,325.00	294,636.30	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,836,257.40	1,777,208.93	59,048.47	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,203.20	1,643,444.59	57,758.61	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,566.00	752,915.71	14,650.30	98.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,567.90	93,737.75	7,830.15	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,221.80	253,961.18	9,260.62	96.5
2104	Хангамж, бараа материалын зардал	93,237.50	92,411.57	825.93	99.1
2105	Нормативт зардал	2,000.00	2,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	234,754.20	234,739.10	15.10	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,500.00	10,222.00	278.00	97.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,005.80	146,116.58	24,889.22	85.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,350.00	57,340.70	9.30	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,054.20	133,764.34	1,289.87	99.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,250.00	20,214.05	35.95	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,804.20	113,550.29	1,253.91	98.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	487,003.90	374,016.07	112,987.83	76.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	137,700.00	15,100.00	122,600.00	11.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,460,961.30	2,353,323.71	107,637.59	95.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,008,164.20	2,218,998.01	-	110.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	452,797.10	134,325.70	318,471.40	29.7

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,373.20	-36,373.20	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	223,371.91	223,371.91	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	66.00	62.00	4.00	93.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	30.00	2.00	93.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	30.00	2.00	93.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,916.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,916.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,914.50
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,320.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,544.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,916.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,916.50

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 2 зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудал нь материаллаг мөнгөн дүн 431,345.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,226.7 мянган төгрөгөөс их байх тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 57,200.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 тн-ийн “Кама” маркийн хогны автомашиныг үндсэн хөрөнгийн тайланд орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хөрөнгийг бүртгэл тайланд тусгах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.1.2. Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын эхний үлдэгдлийг 137,904.5 мянга, эцсийн үлдэгдлийг 63,328.8 мянган төгрөгөөр сангийн программын бүртгэлийн дүнгээс зөрүүтэй тайлагнаж, 374,145.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, “14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын нягтлан бодох бүртгэлийн үлдэгдлийг Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний программын үлдэгдлийн дүнтэй тулган шалгах ажлын хэсгийг томилж, 2 бүртгэлийн зөрүүг арилгах, зээлдэгч тус бүрээр үлдэгдлийг тулган тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө орлогод аваагүй	1	57,200.0			1	57,200.0
ХХС-ийн авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй	1	374,145.4			1	374,145.4
Нийт дүн	2	431,345.4			2	431,345.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Тайлант хугацаанд шилэн дансанд 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	1	0
Дүн	1	0	1	0

5. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	2	9,599.5	1	4,391.0	1	5,208.5
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	3,341.0	1	911.0	1	2,430.0
Хоршоо хөгжүүлэх сан	1	374,145.4			1	374,145.4
Орон нутгийн хөгжлийн сан	1	57,200.0			1	57,200.0
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	0.0			1	0.0
Дүн	7	444,285.9	2	5,302.0	5	438,983.9